

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Галт дулаан ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2025/019/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Мөрөн сум
2025 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Аудитор: Б.Ариунтуяа
Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: b_myadagmaa@yahoo.com
Аудитор Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 1/299
танай _____-ны № _____-т

ГАЛТ ДУЛААН ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.МӨНХ-ОЧИР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Галт дулаан ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хөвсгөл аймгийн ЭХ33-ийн 2024 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 09/24 дүгээр тогтоолоор Галт дулаан ХХК-ийн халаалтын зуухны дулаан түгээх сүлжээнд холбогдсон хэрэглэгчдийн дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон байна.

Могойн гол ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 05 дугаар тогтоолоор цэцэрлэг сумын дулааны төвийн хэрэглээнд зориулж нийлүүлэх нүүрсний үнийг 80.0 хувь хөнгөлсөн ба 2024 онд 1,685.5 тн нүүрс хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 641,935.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 636,517.5 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, 2,864.4 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, 2 албан шаардлага хүргүүлж, 2,554.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

Бусад асуудлын хэсэг

Галт дулаан ХХК-ийн тайлант жилд батлагдсан орлогын төлөвлөгөө 99.6 хувийн биелэлттэй буюу 2,864.4 мянган төгрөгөөр тасалдсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6725022152

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

		(төгрөгөөр)	
		2024 оны 01-р сарын 01	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	144,544,029.08	82,697,398.10
1.1.2	Дансны авлага	27,667,519.07	36,212,484.03
1.1.6	Бараа материал	61,912,889.12	77,992,144.29
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	234,124,437.26	196,902,026.42
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,605,957,755.82	1,820,995,668.77
1.2.2	Биет бус хөрөнгө	15,155,500.00	15,036,750.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,621,113,255.82	1,836,032,418.77
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,855,237,693.08	2,032,934,445.18
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	196,709,023.38	110,780,447.59
2.1.1.3	Татварын өр	8,636,754.44	5,978,250.97
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	205,345,777.82	116,758,698.56
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	44,615,930.33	44,615,930.33
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	44,615,930.33	44,615,930.33
2.2	Өр төлбөрийн нийт дүн	249,961,708.15	161,374,628.89
2.3	Эзэмшигчдийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	894,273,469.00	894,273,469.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	416,402,033.53	416,402,033.53
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	14,968,000.00	374,089,396.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	279,632,482.40	276,379,376.81
2.3.10	Тайлант үеийн ашиг алдагдал	0.00	(89,584,459.04)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,605,275,984.93	1,871,559,816.29
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	1,855,237,693.08	2,032,934,445.18

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

		/төгрөгөөр/	
Мөрийн дугаар		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	690,765,380.24	697,181,070.68
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	563,929,426.59	598,376,360.79
3	Нийт ашиг (алдагдал)	126,835,953.65	98,804,709.89
4	Түрээсийн орлого	3,536,363.64	6,290,909.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	56,650,744.00	185,837,805.00
11	Санхүүгийн зардал	143,600.00	160,620.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	(8,681,653.03)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	73,577,973.29	(89,584,459.04)
19	Орлогын татварын зардал	60,520,255.99	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	13,057,717.30	(89,584,459.04)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	13,057,717.30	(89,584,459.04)
24	Орлогын нийт дүн	13,057,717.30	(89,584,459.04)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	258,378,088.74	1,584,021,591.27
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	21,254,393.66	21,254,393.66
2024 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	279,632,482.40	1,605,275,984.93
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	(3,253,105.59)	13,621,954.81
Залруулсан үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	14,968,000.00	276,379,376.81	1,978,019,335.74
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(89,584,459.04)	(89,584,459.04)
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	359,121,396.00	0.00	359,121,396.00
2024 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	894,273,469.00	416,402,033.53	374,089,396.00	186,794,917.76	1,871,559,816.29

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	820,672,118.06	800,891,203.60
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	756,369,331.06	763,411,912.79
	Буцаан авсан албан татвар	0.00	13,621,954.81
	Бусад мөнгөн орлого	64,302,787.00	23,857,336.00
1.2	Мөнгөн зарлага (-)	731,901,851.02	850,242,834.58
	Ажиллагчдад төлсөн	264,268,047.80	314,603,576.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	62,427,754.70	77,339,929.14
	Бараа материал худалдан авахад төлсөн	173,116,614.15	64,567,540.00
	Ашиглалтын зардалд төлсөн	23,589,356.64	40,952,269.07
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	36,938,522.00	139,961,710.00
	Татварын байгууллагад төлсөн	98,546,298.68	99,049,014.30
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	613,000.00
	Бусад мөнгөн зарлага	73,015,257.05	113,155,796.07
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	88,770,267.04	(49,351,630.98)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.1	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	12,495,000.00
2.2	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	12,495,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(12,495,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	88,770,267.04	(61,846,630.98)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	169,776,931.92	144,544,029.08
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	258,547,198.96	82,697,398.10

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1. Нийт орлого					
1.1	Халаалтын орлого	651,699,965.00	651,509,991.44	99.97	189,973.56
1.2	Халуун усны орлого	15,000,000.00	9,640,909.09	64.27	5,359,090.91
1.3	Цэвэр усны орлого	20,909,091.00	23,037,541.86	110.18	(2,128,450.86)
1.4	Хог тээвэр	12,000,000.00	12,890,537.38	107.42	(890,537.38)
1.5	Түрээсийн орлого	6,727,274.00	6,290,909.00	93.51	436,365.00
1.6	Бусад орлого		102,091.00		(102,091.00)
Борлуулалтын орлогын дүн		706,336,330.00	703,471,979.77	99.59	2,864,350.23
2. Нийт зардал					
.2.1	Нийт цалин хөлс	291,023,639.00	297,569,210.83	102.25	(6,545,571.83)
2.2	Цалингийн НДШ	34,078,261.00	43,132,863.55	126.57	(9,054,602.55)
2.3	Нүүрсний зардал	55,866,250.00	20,170,430.00	36.10	35,695,820.00
2.4	Түлээний зардал	1,950,000.00	1,213,000.00	62.21	737,000.00
2.5	Нүүрс тээврийн зардал	76,115,200.00	74,957,309.09	98.48	1,157,890.91
2.6	Түлш шатахууны зардал	37,191,500.00	52,280,427.67	140.57	(15,088,927.67)
2.7	Цахилгааны зардал	32,728,768.00	33,053,600.06	100.99	(324,832.06)
2.8	Хө/ хамгааллын зардал	7,802,300.00	2,585,907.06	33.14	5,216,392.94
2.9	Бичиг хэргийн зардал	1,110,774.00	303,379.73	27.31	807,394.27
2.1	Интернетийн зардал	510,000.00	200,000.00	39.22	310,000.00
2.11	Томилолтын зардал	280,000.00	-	-	280,000.00
2.12	Цэвэрлэ/материал	1,508,000.00	1,221,290.60	80.99	286,709.40
2.13	Сэлбэг хэ-ийн зардал	14,592,500.00	28,670,716.17	196.48	(14,078,216.17)
2.14	Урсгал зардал	500,000.00	2,125,618.03	425.12	(1,625,618.03)
2.15	Төлбөр хураамж	109,025,537.00	12,817,688.57	11.76	96,207,848.43
2.16	Тэт/урамшуулал	60,664,240.00	49,690,000.00	81.91	10,974,240.00
2.17	Зас/ үйлчилгээ зардал	13,905,500.00	1,474,046.07	10.60	12,431,453.93
2.18	Элэгдлийн зардал	125,351,905.00	148,270,580.02	118.28	(22,918,675.02)
2.19	Бусад зардал	2,079,318.00	9,126,718.34	438.93	(7,047,400.34)
2.20.	ТУЗ-ийн зардал	7,063,363.00	4,900,000.00	69.37	2,163,363.00
2.21	Түрээсийн зардал	2,018,182.00	612,000.00	30.32	1,406,182.00
2.22	Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	-	8,681,653.03		(8,681,653.03)
27	Нийт үйл ажиллагааны зардлын дүн	875,365,237.00	793,056,438.82	90.60	82,308,798.18
29	Татварын өмнөх ашиг, /алдагдал/	-169,028,907.00	-89,584,459.05	53.00	-79,444,447.95

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 641,935.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 636,517.6 мянган төгрөгийн 9 алдааг залруулж, 2,864.4 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгч, 2 албан шаардлага хүргүүлж, 2,554.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.1 Залруулсан алдаа:

- Мөнгөн гүйлгээний үзүүлэлтүүдийг 87,505.0 мянган төгрөгөөр буруу илэрхийлснийг аудитын явцад залруулсан.

- Хөрөнгө оруулалтаар ирсэн үндсэн хөрөнгийг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэснээс тайлант үеийн үр дүн ашигтай гарч, 2,425.1 мянган төгрөгийн татвар төлөхөөр бүртгэснийг залруулсан.
- Сумын ИТХ-ын шийдвэрээр Галт дулаан ХХК-д шилжиж ирсэн 109,471.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй орхигдуулсныг аудитын явцад залруулж, орлогоор бүртгэсэн.
- Сумын ОНХС-ын хөрөнгөөр бэлтгэсэн худгийг орлогод авахдаа урьдчилж орсон орлогод 51,000.0 мянган төгрөгийг бүртгэсэн байсныг залруулсан.
- Өмнөх оны аж ахуйн нэгжийн орлогын албан татварт төлсөн 16,875.6 мянган төгрөгийг татварын авлагаар бүртгэснийг залруулсан.
- Тайлант онд худалдан авч, зарцуулсан 12,920.9 мянган төгрөгийн бараа материалыг зарлагадаагүй байсныг залруулсан.
- Тайлант оны зардал 4,595.0 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгэснийг залруулсан.
- Улс төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн ОНХС-ын хөрөнгөөр бэлтгэсэн 249,650.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг орлогоор бүртгэснийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэж залруулсан.
- Могойн голын ТУЗ-аас Галт дулаан ХХК-д нүүрсийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр өгөхөөр шийдвэрлэсний дагуу хөнгөлөлттэй үнээр нүүрсийг орлогод аваагүй, Могойн гол ХХК-тай тооцоо нийлээгүй байсныг аудитын явцад залруулж, тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,418.4.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 10,860.7 мянган төгрөгөөс 5,442.3 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.2 Төлбөрийн акт

- Галт дулаан ХХК-ийн ажилтан Х.Батмөнх, Я.Цэцэгмаа нарт олгосон өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжээс 10 хувийн суутгал хийж, татварын байгууллагад шилжүүлсэн нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1."Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө: 22.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байх тул татварын тайланд залруулга хийж, илүү суутгасан татварыг дээрх иргэдэд буцаан олгох төлбөрийн акт тогтоов.

3.3 Албан шаардлага

- Галт дулаан ХХК нь тайлант онд орлогын төлөвлөгөөг 2,864.4 мянган төгрөгөөр тасалдуулсан, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шатахуун, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлууд батлагдсан төлөвлөгөөнөөс хэтэрсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;” гэж заасныг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.
- Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын зорилтот түвшний мэдээллийг хугацаа хоцроож

мэдээлсэн, дараа жилийн зорилтот түвшинг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;”, 6.1.3.дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор; гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үнэ тарифтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус компанийн төсвийн байгууллагад халаалт, дулаан нийлүүлэх тарифыг 1,580 төгрөгөөр мөрдөхөөр Хөвсгөл аймгийн ЭХЗЗ-өөс баталсан байхад сумын ЗДТГ болон соёлын төвд 1,360 төгрөгөөр нийлүүлсэн нь Эрчим хүчний тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Хэрэглэгч нь зохицуулалттай хангалтын төлбөрийг нийтлэгдсэн тарифаар, зохицуулалтгүй хангалтын төлбөрийг гэрээний үнээр төлнө.” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан тарифыг мөрдөж ажиллах.

2. Компанийн бизнес төлөвлөгөөг батлахтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Галт дулаан ХХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 01 сарын 24-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор тус компанийг 2024 онд 173,528.9 мянган төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан, компанийн бизнес төлөвлөгөөг батлахдаа үнэ тарифын мөрдөлтийг хянаж үзээгүй орлого дутуу баталсан нь Засгийн газрын “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 388 дугаар тогтоолын 2.4 “төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, мөнгөн хөрөнгийн удирдлагыг дээшлүүлж, үр өгөөжийг өсгөх, төлбөрийн чадварын үзүүлэлтийг эрс нэмэгдүүлэх арга хэмжээ авах.” заалттай нийцэхгүй “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Компанийн бизнес төлөвлөгөөний үндэслэлийг сайтар хэлэлцэн баталж байх.

3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.4 заалтад заасан гүйцэтгэх захирлын гэрээ, ажлын гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт, гэрээний биелэлтийг хэлэлцсэн хурлын тэмдэглэл, гэрээг сунгах эсэх шийдвэр, тухайн жилд төлсөн бүх төрлийн албан татвар, төлбөр, хураамж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн мэдээллийг ил тод, цахим хуудсаар мэдээлээгүй нь “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Хууль, журамд заасан мэдээллүүдийг ил тод, цахим хуудсаар мэдээлж байх.

4. Ахмадын сангийн талаар

Илрүүлэлт:

Галт дулаан ХХК нь ахмадын сан байгуулаагүй байгаа нь Ахмадын настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах...” гэж заасантай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ахмадын санг байгууллагын төсөвт тусгаж батлуулах, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
							Залруулсан		Залруула агүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангуудын үзүүлэлтүүдийг буруу илэрхийлсэн	1	87,505.0			1	87,505.0	1	87,505.0		
аймгаас хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийг борлуулалтын орлогоор бүртгэснээс компани ашигтай ажилласан мэт тайлагнаж аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхөөр бүртгэсэн.	1	2,425.1			1	2,425.1	1	2,425.1		
сумаас хөрөнгө оруулалтаар ирсэн үндсэн хөрөнгийг орлогод аваагүй орхигдуулсан	1	109,471.4			1	109,471.4	1	109,471.4		
Сумын хөрөнгө оруулалтаар ирсэн худгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн.	1	51,000.0			1	51,000.0	1	51,000.0		
Өмнөх оны татварт төлсөн мөнгийг татварын авлагаар бүртгэсэн.	1	16,875.1			1	16,875.1	1	16,875.1		
Тайлант онд худалдан авч зарцуулсан бараа материалыг зарлагадаагүй.	1	12,920.9	1	12,920.9			1	12,920.9		
Тайлант оны зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн.	1	4,595.0			1	4,595.0	1	4,595.0		
аймгаас ирсэн хөрөнгө оруулалтыг орлогоор бүртгэсэн	1	249,650.0			1	249,650.0	1	249,650.0		

нүүрсний үнийг хөнгөлөлттэй үнээр аваагүй, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг буруу тооцоолсон.	1	102,075.0			1	102,075.0	1	102,075.0		
Дүн	9	636,517.5	1	12,920.9	8	623,596.6	8	623,596.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, батлагдсан төлөвлөгөөнөөс зардлыг хэтрүүлсэн.	1	2,864.4			1	2,864.4		
Өндөр насны тэтгэвэрт гарсан 2 иргэний тэтгэмжээс татвар суутгасан.	1	2,554.0	1	2,554.0				
Дүн	1	5,418.4	1	2,554.0	1	2,864.4		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын зорилтот түвшний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн зорилтот түвшинг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хуулийн 20-р зүйлд заасан мэдээллийг ил тод, цахимаар мэдээлээгүй.	1	-					1	-
Батлагдсан тарифыг бүрэн мөрдөөгүй, сумын ЗДТГ, соёлын төвтэй тарифт үнээс доогуур үнээр гэрээ байгуулсан.	1	-					1	-
Компанийн ТУЗ-өөс 2024 оны бизнес төлөвлөгөөг 173.5 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан	1	-					1	-
Ахмадын сан байгуулаагүй	1	-					1	-
Дүн	4	-					4	-
Нийт дүн	5	-			1	-	4	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 76/А227185/

Мөрөн сум

ХВА-2025/019 /ЧА-СТ-ОНӨГГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Галт дулаан ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд Галт дулаан ХХК-ийн ажилтан Х.Батмөнх, Я.Цэцэгмаа нарын өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжээс хувь хүний орлогын албан татвар 10 хувиар суутгаж, 2,554,000 (Хоёр сая таван зуун тавин дөрвөн мянга) төгрөгийг татварын байгууллагад шилжүүлсэн зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1."Дараах орлогыг албан татвараас чөлөөлнө: 22.1.1.хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж" гэж заасантай нийцэхгүй үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3. "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Өндөр насны тэтгэвэрт гарах тэтгэмжээс суутгасан 2,554,000 (нэг сая тавин хоёр мянга наян) төгрөгийг татварын байгууллагатай тооцоо хийж эргүүлэн авч, Х.Батмөнхөд 1,654,000 (нэг сая зургаан зуун тавин дөрөв), Я.Цэцэгмаад 900,000 (есөн зуун мянга) төгрөгийг тус тус нөхөн олгох;

2. Актын биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор нотлох баримтын хамт оруулж, баталгаажуулахыг Хөвсгөл аймгийн Галт дулаан ХХК-ийн захирал Б.Мөнх-Очир, нягтлан бодогч Г.Лхамсүрэн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР
Б.АРИУНТУЯА



6724020675



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 40/А227188/

Мөрөн сум

ХАА-2025/019/НА-97А - ОНМУГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Галт дулаан ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Галт дулаан ХХК нь тайлант онд орлогын төлөвлөгөөг 2,864,351 (хоёр сая найман зуун жаран дөрвөн мянга гурван зуун тавин нэг) төгрөгөөр тасалдуулсан, цалин, нийгмийн даатгалын шимтгэл, шатахуун, сэлбэг хэрэгсэл, урсгал засварын зардлууд батлагдсан төлөвлөгөөнөөс хэтэрсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;" гэж заасныг хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.5-т "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн бизнес төлөвлөгөөг үндэслэлтэй тооцож батлуулан биелэлтийг хангах, батлагдсан зардлын хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галт дулаан ХХК-ийн захирал Д.Мөнх-Очир, нягтлан бодогч Г.Лхамсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Б.АРИУНТУЯА



6724020617



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 03 сарын 14 өдөр

№ 69/19271188/

Мөрөн сум

ХАА. 2025/019/ НА. САА. 010211

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Галт дулаан ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын зорилтот түвшний мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, дараа жилийн зорилтот түвшинг мэдээлээгүй.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь "Шилэн дансны тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;" заалт, 6 дугаар зүйлийн 6.1.1-т "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;" 6.1.3 "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор;" гэж заасныг тус тус хэрэгжүүлээгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг ханган мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, биелэлтийг төрийн аудитын байгууллагын Fas.audit.mn цахим системд 2025 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор оруулж, баталгаажуулах;

2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галт дулаан ХХК-ийн захирал Д.Мөнх-Очир, нягтлан бодогч Г.Лхамсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:


ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Б.АРИУНТУЯА



6724030620